

талаар дорвитой судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байгаа нь хязгаар нутгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд Монгол Улсын хилийн суурь судалгааг өөрийн орны болон гадаадын эрдэмтэн судлаачид, хил судлалын байгууллагын туслалцаатай хийж дэлхий нийтэд батагаажуулах шаардлагатай байна. Монголын түүхэн хил, түүхэн газар зүйн талаар Германы монголч эрдэмтэн Вальтер Хайсег 2 боть альбом, Английн монголч эрдэмтэн Ален Сандрес нэг боть зохиол, Норвегийн монголч эрдэмтэн, Татар болон Орос, Хятад, Японы судлаачид эрдэм шинжилгээний олон өгүүлэл бичиж нийтлүүлсэн нь Монголын хилийг ойлгох суурь үзлийг дэлхий нийтэд буй болгов.

Улсын хил хамгаалалт, хил болон хязгаар нутгийн цаг уур, эрдсийн баялаг, ашигт малтмал, нийгэм, эдийн засгийн байдлыг улсын хэмжээнд уг чиглэлээр суурь судалгаа хийдэг эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудын хүч туслалцаанд тулгуурлан судалж, хил судлалын практикт нэвтрүүлэх нь чухал болов.

Иймд Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэгийн үйл ажиллагааг судалгаа шинжилгээ, сургалт арга зүй, сурталчилгааны чиглэлээр улам идэвхижүүлж явуулах шаардлагатай байна.

\*

\*

\*

*ХЦДС-ийн багш,  
магистр Н.Дэмчиг*

## **УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООНД ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРД**

Монгол Улсын Үндсэн хуулийн 4-р зүйлд "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна. Монгол Улсын хилийг хуулиар тогтооно" гэж заасан нь улсын хилийн тухай асуудлыг үндэсний язгуур ашиг сонирхол - үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг гэж хууль ёсоор тунхаглаж байгаа хэрэг юм. Мөн хуулинд Монгол Улсын төр засаг, иргэдээс эх орныхоо үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлын салшгүй хэсэг, улсын хилийн хамгаалалтын талаар хүлээх үүргийг хуульчлан тогтоосон хэд хэдэн заалт бий. Монгол Улсын Хилийн тухай хуулинд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжийн улсын хилийн хамгаалалтад оролцох оролцоо, гүйцэтгэх үүрэг,

эдлэх эрхийг дэлгэрэнгүй тусгаж өгсөн нь Монгол Улсын Үндсэн Хуулийн холбогдох заалтыг тодруулж хуульчлан бататгаад зогсоогүй улсын хилийн хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, хүчний байгууллагуудын эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг тогтоож өгсөн хэм хэмжээ юм.

### **Нэг. Орон нутгийн засаг, захиргааны байгууллагын талаар**

Монгол Улс эх орныхоо хил хязгаарыг тухайн цаг үеийн онцлогт тохирсон арга хэлбэрээр хамгаалж ирсэн арвин баялаг туршлагатай бөгөөд түүхийн аль ч цаг үед улсын хилийн хамгаалалтад туслах хүчний оролцоо тодорхой байр суурь эзэлж байсан бол хилийн цагийн байдлын өнөөгийн өөрчлөлтийн нарийн төвөгтэй нөхцөлд ч урьдын адил чухал хэвээр байна.

Хилийн Цэрэг дахин байгуулагдсан 60-аад оноос хойш улсын хилийн хамгаалалтад туслах хүчнийг зохион байгуулж оролцуулах ажиллагаанд орон нутгийн төр захиргааны байгууллагын гүйцэтгэх үүрэг, оролцох оролцоог нэмэгдүүлэх чиг хандлага давамгайлах болсон нь улс орны хөгжлийн цаг үеийн онцлогт тохирсон зүй зохистой үзэгдэл юм.

90-ээд онд МУ-ын улс төр, нийгэм, эдийн засгийн суурь харилцаанд гарсан үндсэн өөрчлөлтөөс шалтгаалан улсын хилийн хамгаалалтад туслах хүчнийг оролцуулах асуудлын агуулга хэлбэрийг өөрчлөх зүй ёсны шаардлага гарсан бөгөөд энэ талаар манай хилийн цэргийг удирдах байгууллага нэлээд санаачлагатай ажиллаж зохих үр дүнд хүрч чадсан юм. Энэ нь юу вэ гэвэл 1993 онд "Монгол Улсын Хилийн тухай хууль"-ийг УИХ-ын чуулганаар, "Улсын хилийн хамгаалалтад иргэдийг оролцуулах журам"-ыг 1996, 2000 онуудад Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлуулсан явдал юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 19-р зарлигаар 1996 онд батлагдсан анхны журмыг хэрэгжүүлэх хугацаанд улсын хил хамгаалалтад хүч хэрэгсэл хүрэлцэхгүй байсан явдал багасч хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийн илрүүлэлт дээшилж орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага хилийн тухай хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд үлэмж түлхэц болсон.

Энэ хугацаанд хилийн 14 аймгийн 71 сум, 213 багийн нутаг дэвсгэрт 1200 орчим туслах хүчний гишүүд ажиллаж, хилийн зөрчлийн 8 хувийг туслах хүчний гишүүдийн оролцоо, туслалцаатайгаар, 71 зөрчлийг туслах хүчний гишүүд бие даан тус тус илрүүлж шийдвэрлэсэн



байна.

Гэвч хилийн цагийн байдалд нөлөөлж буй гадаад дотоод хүчин зүйлс, нийгмийн амьдралын бүх салбарт эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай уялдуулан өмнөх журмыг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149 тоот зарлигаар батлуулан мөрдөж эхлээд асар удаагүй байна.

Шинэ журам нь туслах хүчний гишүүдэд хөнгөлөлт эдлүүлж урамшуулал олгох, оногдсон үүргээ биелүүлэх эрх зүйн баталгаа бий болгох зэргээр тэдгээрийн улсын хилийн хамгаалалтад оролцох идэвх, сонирхолыг нь дээшлүүлэх, туслах хүчнийг байнгын удирдлагаар хангаж, гүйцэтгэх үүрэг хариуцлагыг боловсронгуй болгох орон нутгийн төр, захиргааны байгууллагуудыг хилийн хамгаалалтад жигд татан оролцуулах зэрэг олон асуудлыг шинээр тусгаснаараа туслах хүчний үйл ажиллагааг өмнөхөөс илүү үр дүнд хүргэх магадлалтай гэж үзэж байна.

Хилийн хамгаалалтад туслах хүчнийг оролцуулах өнөөгийн гол онцлог нь түүнийг улс төр, тагнуулын зэрэг бусад зорилгод ашиглаж ирсэн түүхэн хэв загвараас татгалзаж зөвхөн улсын хилийг хамгаалах зорилгод ашиглах болсон явдал юм.

Мэдээж хэрэг улсын хилийн хамгаалалтад туслах хүчний оролцох оролцоо нь шинэ журам гаргасан төдийхнөөр сайжрахгүй. Тийм учраас хил хамгаалах үйл ажиллагааны үндсэн субъект хилийн цэрэг, ялангуяа улсын хилийн хамгаалалтыг гардан зохион байгуулж байгаа хилийн хороо, сумангийн удирдлага энэ талаар бодитой ажил зохиох ёстой.

Юуны өмнө хилийн цэргийн удирдах бүх шатны байгууллага орон нутгийн төр, захиргааны байгууллага, түүний удирдлагатай ажил албаны амьд холбоо тогтоох шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар энэ нь эд материалын ойр зуурын дэмжлэг авах, баяр ёслолыг хамтарч тэмдэглэх, аж ахуйн чанартай зарим ажлыг хамтран гүйцэтгэх төдийхнөөр хязгаарлагдаж байгаагаас бус хил хамгаалалтад иргэдийг үр дүнтэй татан оролцуулах, туслах хүчний үйл ажиллагааг газар орон дээр нь зохион байгуулж, байнгын амьд бодитой ажиллагаатай болгох хэмжээнд хүрч хараахан чадахгүй байна.

Энэ нь улсын хилийн хамгаалалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төгөлдөржүүлэх явдалтай холбоотой хэдий ч амьдрал дээр дараахь хүчин зүйлээс тодорхой хэмжээгээр шалтгаалж байна. Үүнд :

1. Үндэсний язгуур эрх ашгийн салшгүй хэсэг улсын хилийн хамгаалалтад аймаг, орон нутгийн удирдлагыг хүргэж ажиллуулах

эрх зүйн зохицуулалтын оновчтой механизм дутагдаж байгаагаас тэдгээрийн удирдан зохион байгуулах үйл ажиллагаа нь орон нутгийн өдөр тутмын амьдралтай холбогдсон үндсэн чиг үүргийн хүрээгээр хязгаарлагдаж, туслах хүчнийг зохион байгуулж улсын хилийн хамгаалалтад оролцуулах ажиллагаа эзэнгүйдэж байна.

2. Улсын хилийн хамгаалалтын хүч хэрэгслийн өсөлт хөгжилт, хилийн хороо сумангийн дарга нарын мэргэжлийн ур чадвар, хилийн цагийн байдлын өөрчлөлтийн өнөөгийн хурдацаас мэдэгдэхүйц хоцорч, орон нутгийн төр, захиргааны байгууллагын удирдлага, хил орчмын ард иргэдийг улсын хилийн хамгаалалтад татан оролцуулах, дайчлан зохион байгуулах түвшинд хүрч хараахан чадаагүй хэвээр байна.

### ***Хоёр. Хүчний байгууллагуудын талаар.***

Улсын хилийн хамгаалалтын тогтолцоонд хүчний байгууллагуудын эзлэх байр суурийг Монгол Улсын хилийн тухай хуулийн 38 дугаар зүйлд хуульчлан тогтоож өгсөн бөгөөд энэ нь өдөр тутмын амьдралд хүчний байгууллагуудтай харилцан ажиллагааг зохион байгуулах хэлбэрээр хэрэгжиж байгаа юм. Харамсалтай нь энэ ажиллагаа хагас дутуу мэдээ, мэдээлэл солилцох, нэгэнт гарчихсан хэрэг, учралын араас хамтран хөөцөлдөх төдийхнөөр хязгаарлагдаж байгаагаас бус хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарах гэж буй зөрчлийг урьдчилан илрүүлэхэд чиглэсэн улсын хил хамгаалалтын идэвхтэй арга хэрэгсэл болж хараахан чадахгүй байна.

Энэ нь төрийн хямрал үргэлжилж буй өнөөгийн нөхцөлд хүчний байгууллагуудын ажлын уялдаа холбоог зохицуулах эрх зүйн зохицуулалт дутагдаж, байгууллага, албан тушаалтан бүр тус тусын үндсэн чиг үүрэгтээ явцууран, эх орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн нийтлэг үүргээ умартсантай холбоотой юм.

Хилчин бидний анхаарлын төвд байх ёстой өөр нэг чухал асуудал бол улсын хилийн хамгаалалтад гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг ашиглах явдал юм. Гэтэл өөрчлөлт шинэчлэлтийн далбаан дор улсын хилийн хамгаалалтын үндсэн хүч хэрэгслийн нэг гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг хилийн цэрэгт үгүй хийсэн нь хилийн цэргийн түүхэнд тохиолдсон томоохон гарз, эмгэнэлт явдал гэхэд хилсдэхгүй байх. Ингэснээрээ улсын хилийн хамгаалалтын бүтцийг зэрэмдэглэж, төрийн хуулийг уландаа гишгэгсэд, улсын хил, хилийн дэглэмийг үл ойшоогчдын бохир савар чөлөөтэй хөдлөх боломж, орон зайг нэмэгдүүлж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд улсын хилийн хамгаалалтын үндсэн



**субъект-хилийн цэрэг** маань төрийн аль нэг яам, газрын хажуу бөөрөнд хавчуулагдаж улсын хилийн талаар бие даасан бодлого явуулах нь бүү хэл төсөв хөрөнгөө захиран зарцуулах хүртэлх наад захын эрх дархаа эдэлж чадахгүйд хүрч хил хамгаалалтын хүч хэрэгслийн өсөлт, хөгжилт энэ хэмжээгээр саарч, буурч байна.

Тийм учраас "Улсын хил хамгаалалтын талаар төрөөс баримтлах бодлогын үндэс", "Улсын хилийг хамгаалах тухай хууль" - ийг боловсруулан гаргаж, холбогдох бусад хууль тогтоомжид байгаа улсын хил, хилийн хамгаалалт, хилийн цэрэгтэй холбоотой зүйл заалт, үзэл баримтлалыг эргэж харах, өөрчлөх замаар улсын хил хамгаалалтын эрх зүйн үндсийг нийгмийн өнөөгийн захиалга, шаардлагын дагуу шинэчлэн өөрчилж, баталгаажуулах явдал мэргэжлийн байгууллагын өмнө урьд урьдаас улам хурцаар тавигдаж байна.

\* \* \*

*ХЦДС-ийн ШНА-ны тэнхимийн эрхлэгч, дэд  
профессор, дэд хурандаа Б.Ахагва.*

## **ХИЛИЙН ЦЭРГИЙН АР ТАЛ ХАНГАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ТОЛӨВШИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ**

Монгол оронд тодорхой зорилго чиглэлээр үүсч байгуулагдсан улс төрийн намууд засгийн эрхийн төлөө тэмцэлдээ хилийн асуудлыг ашиглаж байгаагаас хил хамгаалалтын төв байгууллага засгийн эрх баригч хүчний бодлогоор нэг байгууллагын харьяаллаас нөгөө байгууллагад ойр ойрхон шилжсэнээс, ар тал хангалтын тогтолцоо нь зарим талаар алдагдахад хүрч байна.

Иймээс төрийн хилийн бодлогыг зөв тодорхойлж онолын үндэслэлийг оновчтой гаргаж тавих нь манай эрдэмтэд, багш нарын гол зорилт болж байна.

Манай орны эдийн засгийн өнөөгийн байдал нь хилийн цэргийг хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бүрэн хангаж хараахан чадахгүй байна. Үүний хажуугаар албан тушаалын хийрхэл, хүнд сурталч нэрмээс болж байна.

Хилийн цэрэг БХЯ-ны харьяалалд байсан сүүлийн дөрвөн жилд улсын төсвөөс авах санхүүжилтийн 30 орчим хувийг дутуу авсны гадна